



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**



Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	8
2.8.2	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар	9
2.8.3	Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар	9
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11.	Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал	12
3.1	Зардлын данстай холбоотой асуудал	12
3.2	Бараа материалын данстай холбоотой асуудал	12
4	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
4.1	Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	15
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.5	Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
5	Хавсралт.....	20
5.1	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Авлитын Олон Улсын Стандарт
ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА Ц.ГАНХҮҮ ТАНАА

2019.03.25 № 01/568
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



Үүрэг хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



С.ОЮУНБИЛЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Ц.Ганхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн зардлын данс, бараа материалын данстай холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 5-наас 2019 оны 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Энхжин гүйцэтгэв.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 713 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын эрхэм зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези, зураг зүй, суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалтын салбарын шинжлэх ухаан, технологийн, орон зайн мэдээллийн менежментийн талаарх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

- Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд геодезийн бүх төрлийн сүлжээ, байр зүйн болон сэдэвчилсэн тоон зураглалын тогтолцоог байгуулж, хэрэглээг арга зүйгээр хангах, батлагдсан солбицлын тогтолцоо тусгагт нутаг дэвсгэрийн хэлбэр хэмжээг тодорхойлох;
- Улсын хэмжээнд газрын төлөв байдал, чанарын мониторингийн сүлжээ байгуулж, улсын хэмжээнд нэгдсэн дүгнэлт, зөвлөмж гаргах, салбар дүндын суурь судалгаа, мониторингийн мэдээллийн сан байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэх, газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
- Иргэд, олон нийтийн оролцоо, салбар хоорондын уялдаа холбоог хангасан, геологи, хүрээлэн буй орчны төлөв байдал, байгалийн нөхцөл, нөөцийн иж бүрэн мэдээлэлд суурилсан тогтвортой газар ашиглалтыг төлөвлөх, улсын хэмжээнд газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхлэх, хяналт тавих, газар зохион байгуулалтын төлөвлөгөөний нэгдсэн мэдээллийн сан, удирдлагын нэгдсэн системийг байгуулж, хэрэглэгчдэд мэдээллээр үйлчлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах;
- Нийт нутаг дэвсгэр дээрх эдлэн газар, үл хөдлөх хөрөнгө, нөхцөл байдал, үйл ажиллагааг төрийн өмнөөс кадастрын хэмжилт, зураглал, хаягжилт, бүртгэлээр баталгаажуулах, байрлал бүхий үл хөдлөх хөрөнгийн иж бүрэн мэдээллийн сан, хувийн хэрэг, газрын бирж, үнийн мэдээ, үнэлгээ, төлбөр, татварын тогтолцоог байгуулж, төрийн нэрийн өмнөөс хэрэглэгчийг баталгаат мэдээллээр хангах;
- Геодези, зураг зүйн суурь бүхий геологи, хүрээлэн буй орчин, газар ашиглалтын төлөвлөлт, түүний зохион байгуулалт, газрын кадастрын зэрэг байрлалд суурилсан орон зайн мэдээллийн менежментийг газар зүйн мэдээллийн систем, мэдээллийн технологийн дэвшилтэт технологи ашиглан удирдан зохион байгуулах, хамтын ажиллагаанд тулгуурлан үндэсний орон зайн өгөгдлийн дэд бүтэц байгуулах замаар байгаль, нийгэм, эдийн засгийн бодлого, төлөвлөлт, шийдвэр гаргалтыг суурь орон зайн мэдээлэл, үйлчилгээгээр хангах, олон нийтэд түгээх, мэдээллийн ил тод байдлыг хангах;



- Байгууллагын болон газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн салбарын үндсэн архивыг бүрдүүлэн, архивын сан хөмрөг үүсгэх, архивлах, хэрэглэгчдэд үйлчлэх, геодезийн хэмжил зүйн лабораторийн үйл ажиллагааг эрхлэх;
- Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшил, бүс нутаг, хот суурин газрын хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлын харилцан уялдааг зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах, хяналт тавих, хот байгуулалтын салбарын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, холбогдох эрх зүйн болон норм, нормативын баримт бичгийг боловсруулах, мөрдүүлэх, хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох, хот байгуулалтын баримт бичигт экспертизийн дүгнэлт гаргах, экспертийг сонгон шалгаруулахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах;
- Хот байгуулалтын кадастрыг хот, суурин газарт эрхлэх, улсын нэгдсэн системийг бий болгох ажлыг зохион байгуулах, норм, дүрэм, журам, заавар, аргачлал, стандартыг боловсруулах, мөрдүүлэх, хот байгуулалтын кадастрын мэдээллийг бүрдүүлэх, сан үүсгэх, хөтлөх, хэрэглээнд нэвтрүүлэх, үйлчилгээ үзүүлэх, хот байгуулалтын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ хийх;
- Энэхүү стратегийн зорилтын 2.4.1-2.4.8-д тусгагдсан үйл ажиллагаа тус бүрд тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх дүнд хугацааны стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх техник, технологийн шийдэл бүхий төсөл, тухайн жилийн хамтын ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах бүх төрлийн гэрээ байгуулах, холбогдох хууль тогтоомж, төсөл, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг үнэлэх, хүний нөөц, нийгмийн асуудал, дотоод ажлын зохион байгуулалтыг эрхлэх, байгууллагын үйл ажиллагаанд эрх зүйн үндэслэлээр хангах;
- Санхүү, нягтлан бодох бүртгэл, төсвийн удирдлага болон гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын удирдлага төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Архивын тухай хууль
- Газрын тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Улсын бүртгэлийн тухай хууль
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Улсын бүртгэлийн тухай хууль
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиудад 2018 онд шинэчилсэн найруулга хийгдсэн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “пластик” програм хангамж ашигладаг байна.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дүнд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад удирдлагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үр нөлөөтэй байна гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

ГЗБГЗЗГ-ын үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг Улсын төсвөөс санхүүжүүлдэг тул зардлын гүйлгээг эрсдэлтэй гэж үзсэнтэй холбоотой.



Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны Санхүүгийн үр дүнгийн нийт зардал 69,135.3 сая төгрөгийн 1 хувь буюу 691.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлээр төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшинг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд эрхлэх асуудлын хүрээний 23 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 16 байгууллага аудитад хамрагдсан байна.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Аудитын түүвэрт хамрагдсан	Итгэл үзүүлсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	16	3	4	0
	Дүн	16	3	4	0

Аудитаар 16 санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөгдсөн байна.

2.8.1 Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 900.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 56.8 хувь буюу 511.1 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.3 хувь буюу 2.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.1 хувь буюу 55.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 36.8 хувь буюу 331.5 сая төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 216.7 сая, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлээр 294.4 сая төгрөгийн алдааг залруулсан болно.

ГЗБГЗЗГ-ын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчил түүний шийдвэрлэлтийг дараах хүснэгтээр нэгтгэн үзүүлэв.

(сая төгрөг)

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Үүнээс:									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТШЗ	46	342.7	8	2.4	16	41.9	22	298.5				
2	ТТЗ	3	46.3			1	13.3	2	33.0				
	Дүн	50	389.0	8	2.4	17	55.2	24	331.5				

2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг тоймлон харуулбал:

- Орон нутгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газруудад нийт 234.5 сая төгрөгийн алдаа илэрснээс 219.2 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 13.0 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 2.4 сая төгрөгийн алдаа зөрчилд төлбөрийн акт өгөгдсөн байна.
- Нийслэлийн газрын албаны 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар 108.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 79.3 сая төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж, 28.9 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтахгүй байх талаар албан шаардлага өгөгдсөн байна.
- ГЗБГЗЗГ-ын аппаратын 2018 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгахад нийт 354.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс Барилгын хөгжлийн төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд бүртгэлтэй 294.4 сая төгрөгийн өглөгийг ГЗБГЗЗГ-ын санхүүгийн тайланд авлагаар бүртгүүлж аудитын явцад залруулав. Мөн 46.3 сая төгрөгийн залруулаагүй алдаа зөрчилд 33.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 13.3 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага өгөгдсөн болно.

2.8.3 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын дүнгийн талаар

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлсэн горим сорилын гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитаар илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Асуудал: Зардлын данс

Төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас нийт 13.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Шийдэл:

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Засгийн газрын 2014 оны 128 дугаар тогтоолоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар төсвийн төвлөрүүлэн захирагч байхаар тогтоосон боловч дээрх тогтоол нь Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд “Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх”, 61.1.5-д “Газрын харилцаа, кадастр” гэж заасантай зөрчилдөж байна.



2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 10 хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан 13,438.3 сая төгрөгийн төсөв зарцуулах, үүний 2,910.5 сая төгрөгийг улсын төсвийн орлогоос, 10,559.5 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжүүлэхээр батлагджээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орлого, зардлын гүйцэтгэлийг талаар:

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь 1,815.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдаж, тайлант онд 2,332.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 28.5 хувиар буюу 516.9 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн байна. Зардлын нийт гүйцэтгэл 13,416.5 сая төгрөг буюу 99.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 565.3 сая төгрөгийн орлого төвлөрч, 512.6 сая төгрөгийг зарцуулж 54.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт оруулбал зохих 107 мэдээллээс хугацаандаа оруулсан 96 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн 11 мэдээлэл байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгснөөс 5 зөвлөмжийг хэрэгжүүлж, 100 хувийн биелэлттэй байна.

ГЗБГЗЗГ-ын нэгтгэсэн санхүүгийн тайланд хамрагдсан байгууллагуудад илэрсэн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан бичиг боловсруулан 21 аймгийн ГХБХБГ, Нийслэлийн газрын албанд хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан байна. Мөн 2018 оны эхний хагас жилийн тооллогын дүнг үндэслэн малын үнийг газрын даргын тушаалаар шинэчлэн тогтоосон байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтаар баталгаажуулж, гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан



үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас нийт 28.7 сая төгрөгийн цалин хөлс олгосон байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг хэтрүүлэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасантай тус тус хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

"Улсын бүртгэлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор газрын гэрчилгээ шинэчлэгдэж, хуучин гэрчилгээ хүчингүй болсон боловч бараа материалд бүртгэлтэй байгаа нэг бүрийн үнэ нь 770 төгрөгийн үнэтэй 5665 ширхэг буюу нийт 4.3 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалыг акталж, данс бүртгэлээс хасаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хүчингүй болсон гэрчилгээг ашиглах.



3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-т “Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэж заасны дагуу данс бүртгэлээс хасах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Асуудлын бүртгэлээр танилцуулж, зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 9 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,892,061.8	1,707,405.1
Мөнгөн хөрөнгө	497,655.8	77,861.7
Авлага	161,316.1	27,370.6
Урьдчилгаа	75,569.6	363,672.1
Бараа материал	1,157,494.7	1,238,500.6
Нөөцийн бараа	25.7	0.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	16,287,276.4	14,860,473.4
Үндсэн хөрөнгө	16,287,276.4	14,860,473.4
Биет хөрөнгө	10,638,117.8	10,567,410.6
Биет бус хөрөнгө	5,649,158.6	4,293,062.8
Нийт хөрөнгийн дүн	18,179,338.3	16,567,878.5
Нийт өр төлбөр	291,208.1	398,164.8
Богино хугацаат өр төлбөр	291,208.1	398,164.8
Өглөг	5,716.1	6,478.8
Урьдчилж орсон орлого	285,492.0	391,686.0
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,888,130.2	16,169,713.6
Засгийн газрын хувь оролцоо	17,888,130.2	16,169,713.6
Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,542,374.3	8,720,551.3
Өмч /төрийн/	7,542,374.3	8,720,551.3
Хуримтлагдсан үр дүн	10,111,241.2	6,507,577.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	234,514.7	941,585.3
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	18,179,338.3	16,567,878.5



4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны орлогын дүн	32,678,779.9	66,285,685.8
Татварын орлого	0.0	0.0
Татварын бус орлого	4,724,486.9	4,687,844.2
Нийтлэг татварын бус орлого	4,724,486.9	4,687,844.2
Тусламж, санхүүжилтийн орлого	27,954,293.0	61,597,841.6
Үйл ажиллагааны зардлын дүн	33,300,004.7	69,135,315.2
Урсгал зардал	33,300,004.7	69,135,315.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	26,947,194.7	63,842,355.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,993,573.5	8,924,124.4
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	664,173.1	1,093,467.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	491,970.7	443,280.9
Хангамж, бараа материалын зардал	812,401.7	1,088,316.5
Нормативт зардал	6,781.1	9,784.4
Эд хогшил, урсгал засварын зардал	194,006.8	148,353.2
Томиллолт, зочны зардал	118,340.3	145,895.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,491,893.3	46,834,301.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,174,054.1	5,154,830.3
Хүү		
Татаас		
Урсгал шилжүүлэг	6,352,810.0	5,292,960.2
Хөрөнгийн зардал		
Үйл ажиллагааны үр дүн	-621,224.8	-2,849,629.5
Үйл ажиллагааны бус орлогын дүн	120.7	0.0
Үйл ажиллагааны бус зардлын дүн	39,810.2	819,940.8
Үйл ажиллагааны нийт үр дүн	-660,914.3	-3,669,570.2



4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	31,353,962.6	65,695,205.2
Татварын орлого	0.0	0.0
Татварын бус орлого	2,700,707.2	3,451,080.0
Нийтлэг татварын бус орлого	2,700,707.2	3,451,080.0
Тусламж, санхүүжилтийн орлого	28,653,255.4	62,244,125.2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	29,200,557.0	65,579,692.2
Урсгал зардал	29,200,557.0	65,579,692.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	22,870,680.3	60,179,899.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,107,920.2	8,967,865.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	624,058.9	1,067,226.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,170.8	483,515.3
Хангамж, бараа материалын зардал	437,673.2	464,461.5
Нормативт зардал	13,995.4	16,373.0
Эд хогшил, урсгал засварын зардал	190,063.6	157,754.1
Томилолт, зочны зардал	176,124.4	301,784.3
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,229,137.3	47,885,546.4
Бараа үйлчилгээний бусад зардал	677,536.3	835,372.3
Хүү	0.0	0.0
Татаас	0.0	0.0
Урсгал шилжүүлэг	6,329,876.7	5,399,792.9
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	2,153,415.6	115,513.0
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн	0.0	0.0
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	1,811,390.8	535,307.1
Хөрөнгийн зардал	1,811,390.8	535,307.1
Дотоод эх үүсвэрээр	1,811,390.8	535,307.1
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	-1,811,390.8	-535,307.1
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.0	0.0
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	342,024.9	-419,794.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	155,640.9	497,655.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	497,655.8	77,861.7



4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Тайлангийн үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,909,803.7		18,909,803.7
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	410,981.7		410,981.7
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,320,785.5		19,320,785.5
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-356,017.4		-356,017.4
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-44,418.5		-44,418.5
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0		0.0
Тайлант үеийн үр дүн	-607,864.8		-607,864.8
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	18,312,484.8		18,312,484.8
2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	17,888,130.2		17,888,130.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	65,906.0		65,906.0
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,954,036.2		17,954,036.2
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	707,070.6		707,070.6
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-644,098.0		-644,098.0
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.0
Тайлант үеийн үр дүн	-1,847,295.2		-1,847,295.2
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,169,713.6		16,169,713.6



4.5 Аудит хийсэн жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-	
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,470,039.4	13,416,547.4	53,492.0	99.6
Урсгал зардал	13,470,039.4	13,416,547.4	53,492.0	99.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	13,271,039.2	13,231,539.3	39,499.9	99.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,604,092.8	8,602,863.4	1,229.4	100.0
Үндсэн цалин	5,881,559.8	5,905,549.6	-23,989.8	100.4
Нэмэгдэл	2,055,776.7	2,046,161.2	9,615.5	99.5
Унаа хоолны хөнгөлөлт	371,820.4	362,461.2	9,359.2	97.5
Урамшуулал	14,185.1	14,837.9	-652.8	104.6
Гэрээт ажлын хөлс	280,750.8	273,853.5	6,897.3	97.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,037,036.2	1,036,864.1	172.1	100.0
Тэтгэврийн даатгал	701,666.8	785,584.5	-83,917.7	112.0
Тэтгэмжийн даатгал	82,154.1	61,853.4	20,300.7	75.3
ҮОМШӨ-ний даатгал	67,480.2	50,097.0	17,383.2	74.2
Ажилгүйдлийн даатгал	18,631.1	14,723.4	3,907.7	79.0
Эрүүл мэндийн даатгал	167,104.0	124,605.8	42,498.2	74.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	504,270.7	478,953.4	25,317.3	95.0
Гэрэл, цахилгаан	38,749.7	32,557.0	6,192.7	84.0
Түлш, халаалт	239,864.4	222,949.7	16,914.7	92.9
Цэвэр, бохир ус	34,875.8	23,760.5	11,115.3	68.1
Байрны түрээс	190,780.8	199,686.2	-8,905.4	104.7
Хангамж, бараа материалын зардал	303,755.6	331,091.7	-27,336.1	109.0
Бичиг хэрэг	60,302.7	72,268.9	-11,966.2	119.8
Тээвэр, шатахуун	152,030.4	176,331.8	-24,301.4	116.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,493.2	40,512.6	2,980.6	93.1
Ном, хэвлэл	120.0	127.0	-7.0	105.8
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	666.5	648.5	18.0	97.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	47,142.8	41,202.9	5,939.9	87.4
Нормативт зардал	8,637.8	8,513.2	124.6	98.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,637.8	8,513.2	124.6	98.6
Эд хогшил, урсгал засварын зардал	99,651.6	104,204.4	-4,552.8	104.6
Багаж, техник, хэрэгсэл	13,305.5	26,384.2	-13,078.7	198.3
Урсгал засвар	86,346.1	65,820.3	20,525.9	76.2
Томилолт, зочны зардал	88,454.2	87,402.2	1,052.0	98.8
Дотоод албан томилолт	88,454.2	87,402.2	1,052.0	98.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,103,821.2	2,057,782.4	46,038.8	97.8
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,537,283.1	1,493,009.4	44,273.7	97.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,117.6	3,774.0	343.6	91.7
Даатгалын үйлчилгээ	13,540.7	13,167.6	373.1	97.2
Тээврийн хэрэгслийн татвар	3,583.6	2,832.9	750.7	79.1



Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,299.5	1,176.7	122.8	90.6
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,797.5	34,667.4	130.1	99.6
Газрын төлбөр	159.8	151.9	7.9	95.1
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	509,039.4	509,002.5	36.9	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	521,319.1	523,864.5	-2,545.4	100.5
Бараа үйлчилгээний бусад зардал	517,958.1	520,503.5	-2,545.4	100.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,361.0	3,361.0	0.0	100.0
Урсгал шилжүүлэг	199,000.2	185,008.1	13,992.1	93.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,911.1	1,860.0	51.1	97.3
Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,911.1	1,860.0	51.1	97.3
Бусад урсгал шилжүүлэг	197,089.1	183,148.1	13,941.0	92.9
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	76,052.5	62,353.5	13,699.0	82.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	82,466.6	81,910.1	556.5	99.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,570.0	38,884.5	-314.5	100.8
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	13,470,039.4	13,416,525.3	53,514.1	99.6
Улсын төсвөөс санхүүжих	13,470,039.4	13,416,525.3	53,514.1	99.6
Улсын төсвөөс санхүүжих	2,910,526.7	2,910,147.4	379.3	100.0
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	10,559,512.7	10,506,378.0	53,134.7	99.5
Ажиллагсадын тоо	910	1,008	-98	110.8
Удирдах ажилтан	25	25	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	808	900	-92	111.4
Үйлчлэх ажилтан	77	83	-6	107.8



5 Хавсралт

5.1 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2019/11/СТА-ТТЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.	13.3	Албан шаардлага өгөх	ГЗБГЗЗГ-ын Дарга	Ц.Ганхүү
				СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч	Л.Лувсан
2	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас нийт 28.7 сая төгрөгийн цалин хөлс олгосон	28.7	Зөвлөмж өгөх	ГЗБГЗЗГ-ын Дарга	Ц.Ганхүү
				СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч	Л.Лувсан
3	"Улсын бүртгэлийн тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор газрын гэрчилгээ шинэчлэгдэж, хуучин гэрчилгээ хүчингүй болсон боловч бараа материалд бүртгэлтэй байгаа нэг бүрийн үнэ нь 770 төгрөгийн үнэтэй 5665 ширхэг буюу нийт 4.3 сая төгрөгийн үнэ бүхий бараа материалыг акталж, данс бүртгэлээс хасаагүй байна.	4.3	Зөвлөмж өгөх	ГЗБГЗЗГ-ын Дарга	Ц.Ганхүү
				СЭЗХ-ийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч	Л.Лувсан
Нийт дүн		46.3			



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2019 оны 03 дугаар сарын 25 № 04/130
СМГ - 2019/11/СТА - ТТЗ

Улаанбаатар хот

┌ Зөрчил арилгуулах тухай ─┐

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлаас 13,328.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 42 дугаар зүйлийн 42.7-д "Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой зөрчлийг 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор арилгаж, биелэлтийг 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүү, Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий санхүүч Л.Лувсан нарт даалгав.
2. Дээрх зөрчлийг дахин гаргахгүй байхад анхаарч холбогдох арга хэмжээ авч ажиллах.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Б.ЭНХЖИН

ЗӨВШӨӨРСӨН:
ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГА
Ц.ГАНХҮҮ
САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД
ЕРӨНХИЙ САНХҮҮЧ

Л.ЛУВСАН
Л.ЛУВСАН

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хургуулна" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүднэ.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 25 lines spaced evenly down the page.